



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/01

Шивээговь сум

Цэргийн бүртгэл зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 17.1.9, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан “Цэргийн бүртгэл явуулах журам”, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр “Цэргийн бүртгэл явуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 01 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Л.Чанцалмаа
(1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Маналмаа
(2 дугаар багийн Засаг дарга)
Н.Амаржаргал
(Мэдээ, мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан)
Д.Амартүвшин
(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичиг: М.Гантуяа
(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

3. Цэргийн бүртгэлийн ажлыг заасан хугацаанд чанартай зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлэхийг комиссын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42125003